



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

᠒᠐᠒3 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 44

Сангийндалай

Сумын амьжиргааг дэмжих зөвлөлийг  
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хууль тогтоомжид заасан нөхцөл болзлын дагуу нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэдийг өөрсдийнх нь оролцоотойгоор тэдэнд үзүүлэх үйлчилгээний төрөл хэлбэрийг сонгох санал шийдвэрээ нийгмийн халамж үйлчилгээний байгууллагад уламжлах, шийдвэрлүүлэх үүрэг бүхий амьжиргааг дэмжих зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Сумын Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн төвийн дарга

Ахмадын хорооны дарга

П.Нямдорж /Иргэний төлөөлөл/

С.Оюунчимэг /Иргэний төлөөлөл/

2. Дэмжлэгт хамрагдах өрх, иргэдийг цаг тухайд нь үнэн зөв шийдвэрлэн ажиллахыг зөвлөлд, зөвлөлийн ажлын тайланг хагас, бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг зөвлөлийн даргад даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 24 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.ЧУЛУУН